



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

### Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.2, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм батлах тухай”-ын дүрмийн 7.3, Газрын дүрмийн 7.1.1, Хөдөлмөрийн дотоод журмын 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын Зөвлөх инженер, Мэргэшсэн архитектор, мэргэшсэн инженерийн нэмэгдлийг хавсралтад нэр дурьдсан дараах албан хаагчдад үндсэн цалингийн 10-20 хувиар тооцож олгосугай.

2.Хавсралтаар нэр дурьдсан дараах албан хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа дуусах хүртэлх хугацаанд сар бүр олгож ажиллахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ